



**АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН НЭГДСЭН ХОЛБОО
НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2026 оны 01 сарын 15 өдөр

Дугаар 31/26

Улаанбаатар хот

Салбар холбоодын үйл ажиллагааг дэмжих тухай

Аялал жуулчлалын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дахь хэсэг, Аялал жуулчлалын мэргэжлийн нэгдсэн холбооны дүрмийн 28 дугаар зүйлийн 28.1.13 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Салбар холбоодын үйл ажиллагааг чадавхжуулах, арга зүйн зөвлөгөө өгөх, ажлын албатай уялдаатай ажиллах байдлыг нэмэгдүүлэх зорилгоор “Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо” нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн дэд ерөнхийлөгч нарыг салбар холбоодод дэмжлэг үзүүлэхээр томилсугай.
 - 1.1 Дэд ерөнхийлөгч, Удирдах зөвлөлийн гишүүн Э.Тэнгисболд дараах салбар холбоодын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх болно.
 - a. Гадаад аялалын салбар холбоо
 - b. Монгол Японы аялал жуулчлалын салбар холбоо
 - c. Монголын жуулчин тээврийн салбар холбоо
 - d. Архангай аймгийн аялал жуулчлалын салбар холбоо
 - 1.2 Дэд ерөнхийлөгч, Удирдах зөвлөлийн гишүүн Б.Дуламсүрэн дараах салбар холбоодын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх болно.
 - a. Америк Монголын аялал жуулчлалын хөгжлийн тэгш нийгэмлэг
 - b. Жуулчны базз байршуулах хэрэгслийн салбар холбоо
 - c. Мэргэжлийн Хөтөч тайлбарлагчийн салбар холбоо
 - 1.3 Дэд ерөнхийлөгч, Удирдах зөвлөлийн гишүүн Д.Батболд дараах салбар холбоодын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх болно.
 - a. Боловсрол хөгжлийн нийгэмлэг
 - b. Адал явдалт аялал жуулчлалын мэргэжлийн холбоо
 - c. Нутгийн иргэдийг түшиглэсэн аялал жуулчлал эрхлэгчдийн салбар холбоо
 - 1.4 Дэд ерөнхийлөгч, Удирдах зөвлөлийн гишүүн Н.Сүрэнбаатар дараах салбар холбоодын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх болно.
 - a. Европ зах зээлийн салбар холбоо
 - b. Хятад зах зээлийн салбар холбоо
 - c. Сэлэнгэ аймгийн аялал жуулчлалын салбар холбоо
 - 1.5 Дэд ерөнхийлөгч, Удирдах зөвлөлийн гишүүн В.Батзориг дараах салбар холбоодын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх болно.
 - a. Монгол Солонгосын зах зээлийн аялал жуулчлалын холбоо /МОКТА/
 - b. Булган аймгийн аялал жуулчлалын салбар холбоо

- c. Төв аймгийн аялал жуулчлалын салбар холбоо
 - d. Дорноговь аймгийн аялал жуулчлалын салбар холбоо
2. “Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо” нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн дэд ерөнхийлөгч нар болон салбар холбоодын хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэхийг ажлын албанд даалгасугай.

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



О.МӨНХНАСАН